



НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2015 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 85

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг, дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 9 дүгээр зүйлийн 9.2, 18 дугаар зүйлийн 18.1.2 "л", Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.4, Хот байгуулалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5, 14 дүгээр зүйлийн 14.5 дахь заалт, Улсын Их хурлын 2010 оны "Монгол мал үндэсний хөтөлбөр" батлах тухай 23 дугаар тогтоол, Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, "2030 он хүртлэх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг батлах тухай 23 дугаар тогтоол, Засгийн Газрын 2003 оны "Хөтөлбөр батлах тухай" 160 дугаар тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 119 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1."Нийслэлд мал аж ахуй эрхлэх журам"-ыг хавсралтаар баталсугай.

2."Нийслэлд мал аж ахуй эрхлэх журам"-ын талаар нийслэлийн нутаг дэвсгэрт мал аж ахуй эрхэлж байгаа иргэд, аж ахуй нэгж, байгууллагуудад танилцуулан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, шаардагдах хөрөнгийг Нийслэлийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн жил бүрийн үндсэн чиглэлд тусган ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /Э.Бат-Үүл/-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба /Б.Энхболд/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАТТУЛГА



1110100255

Нийслэлийн нутаг дэвсгэрт мал аж ахуй эрхлэх журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол улсын хот байгуулалтын хүрээнд хүн амын нутагшилт, суурьшил болон хот төлөвлөлтийн дагуу хот орчмын бүсэд мал аж ахуйг эрчимжсэн хэлбэрээр хөгжүүлж хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэхэд төр, аж ахуй нэгж, байгууллага, иргэний хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Нийслэлийн нутаг дэвсгэрт мал аж ахуй эрхлэх журам нь Монгол Улсын үндсэн хууль, Хот байгуулалтын тухай хууль, Газрын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолоор батлагдсан Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага, Төрөөс мал аж ахуй эрхлэх талаар баримтлах бодлого, Монгол мал хөтөлбөр болон эдгээртэй нийцүүлэн гарсан хууль тогтоомжийн бусад эрхийн актаас бүрдэнэ.

Хоёр. Журмын нэр томъёоны тодорхойлолт

2.1. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно:

2.1.1. "малчин" гэж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.9-д заасан этгээдийг;

2.1.2. "фермер" гэж зохих журмын дагуу бүртгүүлэн фермерийн аж ахуй эрхэлж буй насанд хүрсэн, хөдөлмөрийн чадвартай иргэнийг;

2.1.3. "Хамтын фермерийн аж ахуй" гэж нэг гэр бүл эсхүл иргэн дангаараа эрхэлж буй фермерийн аж ахуйг;

2.1.4. "ферм" гэж хувийн өмчлөл, эзэмшлийн болон гэрээгээр эзэмшсэн газар дээр аж ахуй эрхэлдэг хувийн өмчийн аж ахуйг;

2.1.5. "фермерийн аж ахуй" гэж иргэдийн өмчлөл, эзэмшлийн болон гэрээгээр ашиглаж буй газар дээр тулгуурлан эрчимжсэн хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж хувиараа эрхлэх аж ахуйн хэлбэрийг;

2.1.6. "фермерийн аж ахуйн тэргүүн" гэж энэ журмын 5 дугаар зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээх фермерийг;

2.1.7. "Хагас эрчимжсэн аж ахуй" гэж байнгын эзэмшлийн газартай, хүйтний улиралд малаа нэмэгдэл тэжээлээр хангах, зохих хэмжээний өвс тэжээл бэлтгэх

хадлан, тариалангийн талбайтай, дулааны улиралд бэлчээрийг бүрэн, хүйтний улиралд хагас бэлчээрийг ашигладаг хэв шинж;

2.1.8. “Эрчимжсэн мал аж ахуй” гэж эрчимжсэн аж ахуйдаа хөрөнгө оруулалт хийж нэгжээс авах ашиг шимийг нэмэгдүүлэн үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх хэлбэрийг;

2.1.9. “Бэлчээрийн мал аж ахуй” гэж малчид нь нэг газар байнга оршин суудаггүй гэр бүлийн хамт малаа дагаж нүүдэллэдэг, газар тариалан эрхэлдэггүй өрхийн аж ахуйг;

2.1.10. “Хагас бэлчээрийн мал аж ахуй” гэж өмчийн буюу эзэмшсэн газартай, байнгын хашаа байртай /өвөлжөө, хаваржаа/ боловч жилийн урин дулааны улиралд бэлчээр сэлгэн нүүдэг өрхийн аж ахуйг.

#### **Гурав. Мал аж ахуйн эрхлэх үйл ажиллагааны хэлбэр, хамрах хүрээ**

3.1. Нийслэлд Мал аж ахуйг дараах хэлбэрээр хөгжүүлнэ. Үүнд;

3.1.1. Бэлчээрийн мал аж ахуй

3.1.2. Хагас бэлчээрийн мал аж ахуй

3.1.3. Эрчимжсэн мал аж ахуй

3.1.4. Хагас эрчимжсэн аж ахуй

3.2. Багануур, Багахангай, Налайх дүүргийн зарим хэсэг болон таталцлалын бүсэд бэлчээрийн, хагас бэлчээрийн, хагас эрчимжсэн мал аж ахуйг эрхлэн явуулна.

3.3. Нийслэлд дараах зөвшөөрөгдсөн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйг үйлдвэржсэн хэлбэрээр эрхлэн явуулна. Үүнд:

а/ Багануур, Багахангай, Налайх дүүргийн зарим хэсэг, Сонгинохайрхан дүүргийн Жаргалант, Хан-Уул дүүргийн 12, 13, 14 дүгээр хороод, Баянзүрх дүүргийн Улиастай орчмын нутгийг эрчимжсэн мал аж ахуй фермерийн аж ахуйн бүс нутаг болгон хөгжүүлэх;

б/ Сонгинохайрхан дүүргийн 21, 32 дугаар хороод, Хан-Уул дүүргийн 12, 13 дугаар хороод, Баянзүрх дүүргийн 11, 20 дугаар хороод, Налайх дүүргийн 4, 7 дугаар хороо, Багануур дүүргийн 2, 4 дүгээр хороо бүхэлдээ, 3, 5 дугаар хорооны зарим хэсэгт Сүү, махны үхрийн эрчимжсэн аж ахуй эрхлэх үхрийн цогцолбор аж ахуйг шинээр байгуулах

в/ Сонгинохайрхан дүүргийн 21, 32, 361-ын гарам, Хан-Уул дүүргийн 12, 13, 14 дүгээр хороод, Багануур, Налайх дүүргийн зарим хэсгийн бүс нутагт тахиа, гахайны цогцолбор аж ахуй эрхлэх;

г/ Багануур, Налайх дүүрэгт мах-ноосны чиглэлийн хонины эрчимжсэн аж ахуйг өргөтгөх, мах сүүний эрчимжсэн аж ахуйг шинээр байгуулах;

3.4. Зөвшөөрөгдсөн бүс нутагт Эрчимжсэн мал аж ахуйг цогцолбор хэлбэрээр үйлдвэржүүлэн хөгжүүлэхийн тулд дараах шалгуурыг хангасан байна.



а/ Max, сүүний фермийн аж ахуй нь бод малд шилжүүлснээр 50-с доошгүй толгой малтай /хээлтэгч/ байх

б/ Гахайн аж ахуйн ферм нь 80-с доошгүй мэгжтэй байх

в/ Шувууны аж ахуйн ферм нь 25000-с доошгүй өндөглөгчтэй байх

### **Дөрөв. Мал аж ахуй эрхлэлтийг зохицуулах бүсүүд**

Нийслэл хотын нутаг дэвсгэрт мал аж ахуй эрхлэлтийг зохицуулах бүсүүдийг дараах байдлаар тогтооно. Үүнд:

4.1 Мал аж ахуй эрхлэхийг хориглох бүс: Энэ бүсэд хотын төвийн Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт бүхэлдээ, Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн Гачуурт, Хонхор, Жаргалант, Эмээлт, Туул тосгон, Өлзийт хорооноос бусад бүх хорооны нутаг дэвсгэр, Богд уул хамрагдана. Мал аж ахуй эрхлэхийг хориглох бүс нутаг, хил заагийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 119 дүгээр тогтоолоор батласнаар дагаж мөрдөнө.

4.2 Мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрөх бүс: Энэ бүсэд Налайх, Багануур Багахангай дүүрэг Сонгинохайрхан дүүргийн 21, 32 дугаар хороо, Хан-Уул дүүргийн 12, 13, 14 дүгээр хороо, Баянзүрх дүүргийн 11, 20 дугаар хороодын нутаг дэвсгэр хамрагдана.

### **Тав. Мал аж ахуй эрхлэгчдийн хүлээх үүрэг**

5.1. Мал аж ахуй эрхлэгчид нь Нийслэлийн мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрсөн бүс нутагт үйл ажиллагаа явуулах бөгөөд нийслэлийн иргэн байна.

5.2. Энэ журмаар тогтоосон бүс нутагт зөвхөн арвин ашиг шимтэй, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх чиглэлийг баримтална.

5.3. Аж ахуй эрхэлж байгаа иргэд, аж ахуй нэгж, байгууллага тухайн дүүргийн Мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний нэгж, Хорооны засаг даргад бүртгүүлж тэдний байнгын хяналтанд ажлаа явуулна.

5.4. Мал, амьтныг өөр аймаг, сумаас авч ирэх, шилжүүлэх, худалдах, мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхдээ мал эмнэлгийн ариун цэвэр, эрүүл мэндийн үзлэгт оруулж, гарал үүслийн гэрчилгээ, баталгаажуулалт авсан байна.

5.5. Нийслэл, дүүргийн мал эмнэлэг, үржлийн алба, үйлчилгээний нэгжээс зохион байгуулж байгаа арга хэмжээ/ үзлэг, шинэжилгээ, урьдчилан сэргийлэх тарилга, туулгалт, боловсруулалт угаалга /-нд мал, амьтныг тогтоосон хугацаанд нь бүрэн хамруулж, эрүүл байлгах нөхцлийг хангана.

5.6. Мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрсөн бүсэд шилжин суурьших

5.7. Баталгаажуулсан өндөр ашиг шимтэй хээлтэгч, хээлтуүлэгчийг үржилд ашиглах замаар малынхаа удмын санг хамгаалах, нэгжээс авах ашиг шимиийг нэмэгдүүлэх, малын үүлдэр угсааг сайжруулах арга хэмжээ авна.



5.8. Мал, амьтанд халдварт болон гоц халдварт өвчний сэжиг бүхий шинж тэмдэг илэрсэн, үхэж хорогдсон тохиолдолд хорооны Засаг дарга, дүүргийн мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний нэгжиid 12 цагийн дотор мэдэгдэж шаардлагатай үед мал эмнэлгийн байгууллагаас тогтоосон хорио цээрийн дэглэмийг чанд мөрдөнө.

5.9. Цөм сүргийн болон гойд ашиг шимт малд бүртгэлжүүлэлт, таних тэмдэг, ээмэгжүүлэлт хийж, үржлийн малын удмын болон үржил ашиг шимиийн бүртгэл хөтөлнө.

5.10. Ойн сан бүхий газар мал бэлчээж ойн санд хохирол учруулсан тохиолдолд экологи эдийн засгийн үнэлгээ тооцон, тухайн эздээр гарсан төлбөрийг барагдуулах арга хэмжээ авах.

### **Зургаа. Нийслэл, Дүүргийн засаг даргын хүлээх үүрэг**

6.1. Нийслэлийн нутаг дэвсгэрт мал аж ахуй эрхлэх хэсэгчилсэн өрөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулах;

6.2. Үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсөл төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг орон нутгийн төсөвт тусган шийдвэрлүүлэх;

6.3. Нийслэлийн Мал аж ахуйн өрөнхий төлөвлөгөөг боловсруулан, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх бүс нутгийг тогтоож, хяналт тавьж ажиллах;

6.4. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэхэд чиглэгдсэн хөтөлбөр, баримт бичиг, журмыг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, хяналт тавьж ажиллах;

6.5. Мал сүргийг ган, зуд, үер, түймэр, газар хөдлөлт, хүчтэй салхи, байгалийн бэрхшээл, малын гоц халдварт өвчин тохиолдсон үед хорио цээр тогтоох, хүн, мал, амьтны халдварт болон гоц халдварт өвчинтэй тэмцэх шаардлагатай бусад арга хэмжээ авах;

6.6. Онцгой нөхцлийн улмаас бий болсон хор уршгийг арилгах зорилгоор улсын нөөц, төрийн өмчийн болон төрийн өмч давамгайлсан аж ахуйн нэгж, байгууллагын тээврийн хэрэгсэл, шаардлагатай гэж үзвэл бусад аж ахуйн нэгж, байгууллагын нөөцийг дайчилж, нөхөх олговор, үнийг төлөх;

6.7. Мал, амьтныг халдварт паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ болон үзлэг шинжилгээнд хамруулж, дүүргийн мал эмнэлэг, үржлийн байгууллагын хяналтанд байлган, гэрээ, захиалгаар гүйцэтгүүлсэн ажлын үйлчилгээний зардлыг холбогдох хуулийн дагуу гарган өгч мал сүргийг эрүүлжүүлэх ажлыг хариуцах;

6.8. Нийслэлд эрчимжсэн мал аж ахуйг цогцолбор хэлбэрээр хөгжүүлж хүн амын хүнсний хэрэгцээгээ хангах бодлогын баримт бичиг боловсруулж ажиллах;

6.9. Хориглосон бүсэд мал амьтан орж ирсэн тохиолдолд дүүргийн тохижилт үйлчилгээний компаниас хариуцаж, тусгай зориулалтын хашаанд хорьж, зохих төлбөртэйгээр эзэнд нь буцааж өгөх буюу зарлан мэдээлээд эзэн нь ирж аваагүй тохиолдолд зохих журмын дагуу улсын орлого болгох;

6.10. Нийслэлийн нутаг дэвсгэрт хөдөө орон нутаг, сумаас мал, амьтан олноор ирж хаваржих, зусах, намаржихийг хориглоно.



**Долоо. Дүүргийн мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний  
нэгжийн хүлээх үүрэг**

7.1. Тухайн дүүргийн нутаг дэвсгэрт мал эмнэлэг, үржлийн нэгж үйлчилгээ явуулж малчид, малтай иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан ажиллана.

7.2. Мал амьтныг халдварт, паразит өвчинеэс урьдчилан сэргийлэх, эмчлэх, шинжлэх, ариутгах, халдвартгүйжүүлэх ажлын талаар жил бүр төлөвлөгөө боловсруулж, батлуулан хэрэгжүүлнэ.

7.3. Мал амьтан болон мал аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүн, түүхий эдийн зах зээлд худалдан борлуулахад хяналт тавьж үзлэг, шинжилгээ хийж гарал үүслийн гэрчилгээ олгоно.

7.4. Хөдөө орон нутгаас ирж байгаа мал амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл мэндийн гэрчилгээ олгох, баталгаажуулахад байнгын хяналт тавина.

7.5. Малын ашиг шимиийн гарц, чанарыг нэмэгдүүлэх, малын үүлдэр угсааг сайжруулах талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад мэргэжил арга зүйн үйлчилгээ туслалцаа үзүүлнэ.

7.6. Малтай иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын дуудлагаар болон гэрээгээр мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээ үзүүлнэ.

7.7. Иргэдэд мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээний талаар анхан шатны мэдлэг олгох сургалт зохион байгуулах, гарын авлага мэдээлэл, шаардагдах багаж хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулна.

7.8. Нийт мал сүрэгт үзлэг хийж, цөм сүрэг, гойд ашиг шимт малыг сонгон шалгаруулж, хээлтэгч малыг бүртгэлд авч гэрчилгээ олгоно.

**Найм. Нийслэлийн Мал эмнэлгийн газар,  
Мэргэжлийн хяналтын газрын хүлээх үүрэг**

8.1. Нийслэлийн хэмжээнд мал, амьтны халдварт, паразит өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын талаар авах арга хэмжээг жил бүр төлөвлөн хэрэгжүүлнэ. Дүүргийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллана.

8.2. Нийслэлийн нутаг дэвсгэрт мал амьтан, мал аж ахуйн гаралтай түүхий эд хүнсний бүтээгдэхүүн оруулах, худалдан борлуулах үйл ажиллагаанд байнгын хяналт тавина.

8.3. Нийслэлийн нутаг дэвсгэрт мал аж ахуй эрхлэгчид болон мал аж ахуйн гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүнээр үйлдвэрлэл үйлчилгээ, худалдаа эрхлэгчдийн үйл ажиллагаанд хяналт тавьж хууль, тогтоомж, дүрэм, журам зөрчигчдөд хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

**Ес. Мал аж ахуй эрхлэгчдэд хориглох зүйл**

9.1. Нийслэлийн нутаг дэвсгэрт Мал аж ахуй эрхлэхэд дараах зүйлийг хориглоно.

